

ХЭЛЦ НЭГЖИЙН НЭРЛЭЛТИЙН ХЭВШИНЖ

Ж.Баянсан*
Л.Ганчимэг*

Ямар нэг юм үзэгдэл, үйл байдал, шинж чанарын нэр үүсэхэд гурван төрлийн хүчин зүйл буюу гурван зүйлийн мөн чанар харилцан уялдаатай болно. Үүнд:

1. Бодит байдал. Үүнийг ерөнхийд нь нэрлэгдэхүүний хүрээ буюу таньж мэдэж болох, улмаар түүнийг тийм, ийм хэмээн нэрлэж болох бүх зүйл хамрагдана.

2. Дүр буюу бодит байдал (1)-ын тухай ухагдахууны тусгал. Хүн ухамсараараа ертөнцийг таньж мэдэх явцдаа түүний тухай ямар нэг төсөөлөл, ойлголт (ухагдахуун) бий болгох төдийгүй, түүнийг өөрийнхөө хэрэгцээ, ашиг сонирхлын үүднээс эерэг сөргөөр үнэлж цэгнэн, айчилж ангилах боломж чадвар байна гэсэн үг юм. Үүнийг ерөнхийд нь дохиожуулах (сигнафикатив) хүрээ хэмээн нэрлэдэг байна. Энэ хүрээ нь бодит байдал буюу реали-ийн ухагдахууны агуулга болдог.

3. Нэр буюу дохиожуулах хүрээний агуулгыг хэлний хэрэглүүрээр илэрхийлэхүй хэмээн гурван бүрэлдүүлбэртэй байна гэж тодорхойлдог ажээ¹.

Шууд бус нэрлэлт² үүсэхэд дээрх гурван зүйлийн мөн чанар харилцан хамааралтай нөхцөлдөхийн хамт өөр бас нэг бүрэлдүүлбэр түүнд нэгдэн нийлдэг байна. Энэ нь юу вэ гэвэл: бодит байдлын тусгалын хэл-ухагдахууны хэлбэр ба түүний нэр буюу шууд бус нэрлэлтийн хэлний хэлбэр хоёрыг зуучлагч бүрэлдүүлбэр юм. Энэхүү зуучлагч бүрэлдүүлбэр гэдэг нь бодит байдлын тухай хэлний илэрхийллийн үндсэн (анхны) утга буюу утгал утгыг хэлж байна.

Харин дам нэрлэлт (косвенная номинация)-ын тухайд энэхүү зуучлагч бүрэлдүүлбэр гэдэг нь юм үзэгдэл, үйл байдал, шинж чанарыг өвөрмөц хэллэгээр нэрлэхийн цагт бодит байдал, түүнийг нэрлэх харьцааны үүднээс авч үзвэл дөрөв биш харин таван бүрэлдүүлбэр оролцоно гэсэн үг юм. Үүнийг дурдвал:

1. Бодит байдал
2. (Бодит байдлын) хэл-ухагдахууны тусгал
3. Зуучлах үүрэг бүхий тулгуур нэрлэлтийн дохиожуулсан тэмдэглэхүүн (сигнафикатив опосредующего опорного наименования)
4. Хэлний хэлбэрийн бүтэц-утгазүй анхдагч утга

* МУИС-ийн Монгол хэл соёлын сургууль

* МУИС-ийн Монгол хэл соёлын сургууль

¹Телия В.Н. *Вторичная номинация и её виды* // Языковая номинация. Виды наименований и языковая номинация. Общие вопросы. М., 1977, х.73.

²Т.Г.Никитина нар “*вторичная номинация*” гэж нэрлэсэн зүйл нь агуулгаараа В.Н.Телия нарын “*непрямая номинация*” гэдэгтэй тохирно.

5. Шууд бус (хоёрдогч) нэрлэлтийн хэлний хэлбэр³. Энэ нь хэлний үзэгдлийг мэдэгдэхүүн-мэдэхүүн-хэл-хэлэхүйн дөрвөн зүйлийн харьцаанд авч үзэх ёстой хэмээсэн (Аристотель, Ф.де. Соссюр, Ш.Лувсанвандан, М.Базаррагчаа) аргагүйн үзэл баримтлалтай агуулгаараа тохирч байна.

Хэрэв хэлцэжмэл нэгжийн дотоод хэлбэр нь мэдэгдэж байвал хэлцэжмэл нэрлэлтийн ихэнх нь ийнхүү хоёр хэмжээст зуучлагч (опосредственность)-тай байдаг ажээ. Тодруулж хэлбэл, бодит байдлын шинж чанарын тухай мэдлэг хэлц нэгжийн үүсгэмэл утгад ямар нэг хэмжээгээр ул мөрөө үлдээсэн байдаг байна.

Хэлц нэгжийн дотоод хэлбэр нь хуурмаг тэмдэглэхүүн үүсгэдэг бөгөөд ийм учраас үүсгэмэл утгын зэрэгцээгээр хуурмаг тэмдэглэхүүн үүсгэдгээрээ хосмолжин оройтой (двувершинность) нэрлэлт болно⁴. Өөрөөр хэлбэл, соёл бол ард түмний өвөрмөц ой санамж (ой ухаан) юм. Хэл ч гэсэн хүн төрөлхтний амьдралын мэдлэг туршлагыг төвлөрүүлэн цогцлоож, нэг талаас урьд бүтээн бий болгосон эдийн болон оюуны соёлын зүйлийг өнөө үеийнхэнд нь мэдээлэн зуучлах, нөгөө талаас, өнөө үеийнхний соёлын зүйлийг ирээдүй хойч үеийнхэд нь холбон залгамжилж өгөх үүрэгтэй байдаг.

Ийнхүү хэл, соёл хоёр харилцан уялдаатай ч, бас харилцан зэрэгцэн орших энэ зүй тогтлын илрэл, илэрхийлэл болгон нь “*мөс зүсэгч хөлөг онгоцны*” зөвхөн нэг л орой нь болохоос биш, уг хөлгийн бүх бие цогцсын хэлбэр нь их төлөв хэлээрээ, хэлнийхээ үзэгдэл баримтаараа тодорхойлогдож байдаг⁵. Аливаа хэл нь түүнийг төрөлх хэлээ болгосон үндэстэн угсаатны соёлынх нь зэмсэг, зэвсэг хэрэглүүрийн үүрэгтэй болохдоо соёлын хэл буюу “*соёлын тэмдэг*”-ийн үүрэгтэй болно. Өөрөөр хэлбэл, хэлний авиа (үсэг), утга хэмээх хоёр талт нэгж нь соёлын тэмдгийн “*бод бие*” (тела)-ийн үүрэг гүйцэтгэх зүй тогтолтой байдаг л хэл, соёлын харилцан хамаарлын мөн чанар оршино⁶.

Хэлц нэгжийг хоёр тэмдэглэгдэхүүн (денотат)-тэй нэрлэлт гэж тодорхойлсон зүйл судлаачдын дунд түгээмэл байна. Жишээлбэл, Н.Н.Кириллова нэг денотат нь хэлц нэгжийн гүн бүтцэд хамаатай байдаг бол нөгөө денотат нь түүний өнгөн бүтцэд хамаатай байна. Энэ нь утгаас хэлбэр лүү чиглэх буюу хэлэхүйг бүтээх талаас нь хандаж байна уу? эсвэл хэлбэрээс утга руу чиглэх буюу тухайн илэрхийллийг сонсогч/уншигч хүлээн авах талаас нь хандаж байна уу гэдгээс хамаараад денотат 1, денотат 2 нь харилцан байраа сэлгэх боломжтой байна⁷ гэж тодорхойлжээ.

Аливаа харилцаа нь өгүүлэгч, сонсогч хоёрын харилцан үйлдэл учраас харилцааны нэг агшинд өгүүлэгч, нөгөө агшиндаа сонсогч/уншигч болдог нь харилцааны зайлшгүй эрэмбэ учраас хэлц нэгжийн харилцааны үүргийг тодорхойлохдоо бас л энэ шинжийг харгалзан үзэх учиртай болно.

³ Языковая номинация. Общие вопросы., М., 1977. х.79-81

⁴ Телия В.Н. Идеографический анализ фразеологизмов //Идеографический и историко-этимологический анализ славянской фразеологии. М., 1994, х.93.

⁵ Телия В.Н. Русская фразеология: Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996, х.226.

⁶ Телия В.Н. Русская фразеология: Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996, х.227.

⁷ Кириллова Н.Н. Сопоставительная фразеология романских языков. Лг., 1986. х.33-34.

Ингэхлээр ямар нэг юм үзэгдэл, үйл байдал, хэрэг явдал, гэрч баримт, шинж чанар зэргийн нэрлэх үйлийн эхлэл нь юмыг нэрлэхийг зорьсон санаа (номинативный замысел) юм.

Өөрөөр хэлбэл, юмыг нэрлэх санаа төрөхөөс ангид нэрлэх үйл ажиллагааны тухай өгүүлэх ямар ч боломжгүй юм. Энэ нь хүний аливаа үйл бол ямар нэг өдөөлөг сэдлэг (мотив)-ээс заавал үүдэлтэй байдагтай холбож ойлгох асуудал юм. Энэхүү учир шалтгааныг монгол зүйрлэлд *“овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ?”* гэх зэрэг утгатай хэллэгүүдээр илэрхийлнэ. Гүн ухаанд *“шалтгаан, үрийн ай”* гэж байдаг нь аливаа үйл үүтгэгдэж, шалтгаанаар нөхцөлдөн, улмаар үйлийн төгсгөл нь ямар нэг үр (дүн)-ийг үзүүлнэ гэсэн шалтгаант холбооны үүднээс авч үздэгтэй холбоотой ажээ.

Бодит ертөнцийн юм үзэгдлийн тухай өгүүлэгчийн бодол санааны агуулга нь сонсогчийнхтой яг таг таарах албагүй, бараг тийм боломж ч үгүй. Харин тэдгээрийн агуулгын давхацлын хэмжээ нь хэчнээн их оронг хамаарч байвал харьцангуй *“бүрэн ойлголцох”* боломжтой бөгөөд үүний эсрэгээр байвал *“хагас дутуу ойлголцох”*-д хүрнэ. Харилцааны энэ онцлог нь өгүүлэгч/сонсогч хоёрын нас, сэтгэцийн онцлог, тэдгээрийн дэвсгэр мэдлэг, амьдралын туршлага зэргээс хамааралтай байна.

Хэлц нэгж нь хоёр зүйлд байгаа ямар нэг төслүү шинжийг нэрлэлтийн үндэс болгож авдаг. Ийм учраас шинээр нэрлэж буй зүйлд жишин харьцуулж буй нөгөө зүйлийн ямар шинжийг адилтгал/жишил/зүйрлэлийн үндэс болгож авсан бэ? гэдэг асуудал зүй ёсоор гарч ирнэ.

Өвөрмөц хэллэгийн утгаар илэрч буй нэрлэлт бол цоо шинэ нэрлэлт учраас түүнийг хоёрдогч тэмдэглэгдэхүүн буюу денотат, эсвэл хоёрдогч нэрлэлт буюу шууд бус нэрлэлт, үгүй бол дам нэрлэлт гэх зэргээр томъёолсон байдаг. Харин анхдагч тэмдэглэгдэхүүн буюу анхдагч нэрлэлт гэдэг нь шинэ (хоёрдогч/шууд бус) нэрлэлт үүсэх үндэс болсон юм үзэгдлийн нэрлэлт юм. Ийм учраас хэлц нэгжийн хувьд энэ денотат буюу тэмдэглэгдэхүүн гэдэг нь чухам ямар онцлогтой?, чухам ямар зүйл байх ёстой вэ? гэсэн асуулт зүй ёсоор гардаг байна.

Ихэнх судлаачид үүнийг нэрлэж буй тухайн объектод тулган үзсэн байдаг ажээ. Хэлц нэгжийн нэрлэлтийн объект гэдэг нь хэлнээс ангид орших юм үзэгдлийн хүрээнд хамаарах зүйл байх нь мэдээж зүйл. Гэвч түүнийг хэлцийн денотат гэж шууд тулган ойлгож болох уу?, үгүй юу? гэдэг асуудлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай болдог байна.

Өөрөөр хэлбэл, дан үг ч юм уу, эсвэл чөлөөт холбоо үгээр илэрхийлсэн нэрлэлт (денотат), хэлц нэгжээр илэрхийлсэн нэрлэлт хоёр ижил юм уу?, эсвэл ялгаатай юм уу?

Хэлний аливаа илэрхийллийн бүтцийнх нь аль нэг элементийг өөрчилбөл түүний агуулгын тал ямар нэг хэмжээгээр заавал өөрчлөгдөнө гэж үздэг. Тэгвэл дан үг, чөлөөт холбоо үг, чөлөөт бус холбоо үг буюу задлаг хам бүтэц, эсвэл өвөрмөц хэллэг зэрэг нь нэгэнт гаргалгын тал буюу хэлбэр-бүтцээрээ ялгаатай учраас агуулгын талаараа бас ялгаатай байх ёстой гэсэн нэг гаргалга зайлшгүй гарч ирнэ. Ийм учраас өвөрмөц хэллэг, ерөнхийлөн хэлбэл, хэлц нэгжээр илэрсэн нэрлэлтийн онцлог нь чухам юу юм бэ? гэдэг асуултад тодорхой хариу өгөх учиртай болж байна.

Юмыг хүн таньж мэдсэний улмаас л түүнийг нэрлэх хэрэгцээ шаардлага гарч ирнэ. Иймд нэрлэлт буюу денотат гэдэг нь аливаа юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг бүхэлд нь ерөнхийлөн нэрлэдэг биш, харин түүний шинжийг нэрлэдэг гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, аливаа юмыг таньж мэдэхэд бусад юмтай уг юм ямар харьцаа хамааралтай байна вэ?. Урьд нь таньж мэдсэн зүйлээсээ шинээр танин мэдэж

буй тухайн зүйл юугаараа ялгарч, түүнтэй бас юугаараа нийтлэг шинжтэй болохыг олж мэднэ гэсэн үг юм. Ингэхлээр юмсыг таньж мэдэх гэдэг бол тэдгээрийн хоорондын харьцааны хэв маягийг таньж мэднэ гэсэн үг болно.

Энэ үүднээс авч үзвэл харьцаа гэдэг нь энэ тохиолдолдоо юм үзэгдлийн шинж байдал гэсэн ойлголттой тохирох утгаар хэлэлцэж болно. Товчлон хэлбэл, танин мэдэх үйл ажиллагаа гэдэг бол юмсын шинжид чиглэн хандсан үйл ажиллагаа юм. Шинж буюу гадаад хэлбэр төрх, эсвэл тэдгээрийн үйлийн онцлогоор дамжсаар дотоод гүнд нь алгуур нэвтрэх аргаар цөм бүтцийн онцлогийг нь нээж гаргах нь танин мэдэх үйл ажиллагааны ерөнхий арга ажээ. Иймээс “денотат” гэдэг нэр томъёог бодит байдлыг шинж (онцлог, онцлог шинж)-ийг нэрлэн тэмдэглэхэд хэрэглэх нь зүйд нийцнэ гэдэгт судлаачдын санал нэгдмэл байдаг байна.

Денотат (нэрлэлт) гэдэг нэр томъёог ийнхүү юмын шинжийг заасан утгаар хэрэглэхдээ:

а. хийсвэр нэрлэлт (идеальный),

б. материаллаг (бодот) нэрлэлт хоёрыг ялгаж үзэх учиртай болдог байна.

Хийсвэр нэрлэлт гэдгийг юмын тухай төлөөлөл гэсэн утгаар, харин материаллаг (бодот) нэрлэлт гэдгийг нэрлэгдэж байгаа юмтай тулган ойлгох ёстой гэж эдгээр судлаачид үзсэн байна. Материаллаг (бодот) нэрлэлтийг референт буюу тэмдэглэхүүний нэр гэсэн утгаар ойлгох ёстой хэмээн үзсэн байна.

Хэлц нэгжийн нэрлэлтийн онцлогийг судлан тайлбарлах гэж байгаа бол “денотат” гэдэг нэр томъёог “хийсвэр” (идеальный) нэрлэлт гэсэн ойлголтоор авч үзэх нь зүйтэй хэмээсэн судлаачдын саналыг бид дагаж байна.

Бид өмнө тэмдэглэснээр, нэрлэлт (номинация)-ийг нэлээд өргөн агуулгаар авч үзвэл үг, холбоо үг, задлаг хам бүтэц, өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэг буюу өгүүлбэр, бас нэгэн тодорхой сэдэв бүхий бичил эх-цогцолборын алинаар нь ч нэрлэлт үүсч болно. Гэхдээ түүнийг багцалж ерөнхийд нь гурван хэв шинжид хураангуйлан үзэж байна. Үүнд⁸

1. Үг ба холбоо үгээр илэрсэн нэрлэлт. Үүнийг үгийн сангийн төвшинд илрэх нэрлэлт буюу “лексическая” гэж тодорхойлсон байна.

2. Өгүүлбэрээр илрэх нэрлэлт. Үүнийг пропозитив нэрлэлт гэсэн байна. Монгол хэлний хэвшмэл хэллэг нь энэ хэв маягийн нэрлэлтэд ерөнхийдөө тохирох үзэгдэл юм.

3. Эхээр илрэх нэрлэлт буюу дискурсив нэрлэлт⁹

Судлаачдын тодорхойлж байгаагаар үүний эхнийх нь юм үзэгдлийг хэсэгчлэн нэрлэх буюу махбодоор нэрлэх байдалтай, харин удаах нь үйл явдал, үйл байдал (ситуация)-ыг нэрлэдэг. Тэгвэл эхээр илэрхийлдэг гуравдах нэрлэлт нь нэг биш, хэд хэдэн үйл явдал (үйл хэрэг, үйл байдал)-ыг нэрлэх онцлогтой ажээ. Энэ ангилал нь нэрлэлтийн ерөнхий шинжид илүү хамаатай байдаг учраас хэрэв түүнийг хэлцийн төвшинд авч үзвэл дээрх эрэмбэ яг таг заагдах боломжгүй гэж үздэг байна.

Одоо өвөрмөц хэллэгээр илрэх нэрлэлтийн онцлогийн талаар нарийвчилсан судалгаа хийж, онол-аргазүйн тодорхой чиг хандлагыг тодорхойлсон зарим судлаачийн гол гол саналыг авч үзье. Жишээлбэл: А.М.Эмирова “Өвөрмөц хэллэгээр үүссэн нэрлэлтийн өвөрмөц онцлог нь бодит байдлын саланги саланги юмсын анги бүлгийг биш, харин тэдгээрийн гол гол шинжийг нэрлэхэд оршино. Юмсын эдгээр гол гол шинж

⁸Никитина Т.Г. Специфика фразеологической номинации //Проблемы фразеологической семантики. СПб. 1996. х.77.

⁹Языковая номинация. Общие вопросы. М., 1977. х.112.

гэдэг нь уг юмаасаа ангид оршдоггүй, бас түүнээс ангид сэтгэх аргагүй, гагцхүү уг юмандаа шингээж орших байдалтай байна”¹⁰

Өвөрмөц хэллэгээр илрэх нэрлэлт нь хэдийгээр юмсын анги бүлгийг биш, юмсын шинжийг нэрлэдэг боловч, чухамдаа уг юманд хандах хандамж, үнэлэмжийн онцлогийг илэрхийлдэг нь түүний үндсэн онцлог юм.

Шинээр таньж мэдсэн, ухаарч ойлгосон, шинээр бүтээн бий болгосон юмыг нэрлэхдээ урьдаас таньж мэдсэн зүйлтэй жишин харьцуулж, шинэ ба хуучин зүйлсийн шинжүүдийг өөр хооронд нь авалцуулан холбож (ассоциатив арга, аналоги-ийн аргыг ашиглах) мэдрэхүйн дүрслиг төсөөлөл, дүрслэн сэтгэх аргад үндэслэж, ингэнгээ сэрэл мэдрэхүй (мэдрэмж), сайн-муу, сайхан-муухай, хэрэгтэй-хэрэггүй, хүсүүштэй-хүсэшгүй, дуртай-дургүй гэх мэт эсрэгцсэн айгаар уг юм үзэгдэлд хандаж буй өгүүлэгчийн үнэлэмж, сэтгэл хөдлөлийн байдал бас нэгэн зэрэг илрэх үйл явц юм. Эдгээр үнэлэмж, сэтгэлийн хөдөлгөөний байдал зэрэг нь уг юмыг таньж мэдэх, улмаар түүний нэрлэх явцад зэргэцэн үүсч буй үзэгдэл болно.

Ер нь аливаа юмыг тусган хүлээж, гүнзгийрүүлэн таньж мэдэх, улмаар түүний тухай тодорхойлон өгүүлэх, энэ явцдаа түүнийг нэрлэн, хэлний тэмдгээр ой ухаандаа бэхжүүлэн хадгалах үйл явц, үйл ажиллагаа болгон нь уг юм үзэгдэл, үйл байдал, шинж чанарын тухай ерийн нэг мэдээлэл (информаци) өгөх төдий бус, түүний тухай ямар нэг үнэлэмж заавал хамт илрэхээс өөр аргагүй байдаг ажээ.

Учир нь танин мэдэж буй, хийж бүтээж буй бүх л үйл ажиллагаа болгон нь хүний амьдрах, аж төрөх хэрэгцээнээс үүдэлтэй байна.

Хүн хэрэгцээгээ хангах гэдэг нь өөрт нь ашигтай юу– ашиггүй юу, уг юм сайн уу –муу юу; сайхан юм уу–муухай юм уу; хэрэгтэй юм уу–хэрэгцээгүй юм уу гэх зэргээр язгуур “*эрх ашиг*”-ийн үүднээс харьцаж хандахаас өөрөөр уг зүйлийг танин мэдэх аргагүй юм.

Юмыг үнэлж цэгнэсэн үр дүн болгон нь газар нутаг, ёс заншил, соёл, хэлнийхээ нийтлэгээр нэгэн омог аймаг, ястан угсаатан, үндэстний нийтлэгийн хувьд нэг төрлийн, ерөнхий нийтлэг зүйл байх болно. Ингэхгүйгээр тухайн үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, ертөнцийн таньсан байдал, уламжлалт соёл, тэдгээрийг илэрхийлэх харилцааны хэрэглүүр болох хэлний мөн чанар зэрэг нь нэгдмэл байж, үндэстэн угсаатныг нэгтгэхийн хамтаар өөр бусад олон аймаг, үндэстэн угсаатнаас ялгаруулах онцлог болж чадахгүй юм.

Өөрөөр хэлбэл,

- харганын унгасаар эсгий хийх,
- үхсэн эмгэнээс унгас асуух,
- төрж ядаж байж төлөгт эх болох;
- ухнад явсан хүү ямаа ишиглэсэн хойно ирэх;
- зул сарын нохой, зургаан сарын бух;
- элгэн хад өөд төлгөн хуц мөргөх;
- хорголоо тоолох;
- ташаанд нь ташуур (хувин) өлгөмөөр;
- нохойн дуу ойртох
- хөлд нь суух

¹⁰ Эмирова А.М. *К вопросу о номинативной сущности фразеологических (идиометических) предикатов* //Вопросы языкознания. 1984. № 6. х.114-115.

- толгойгоо ганзгалах
- гуяа ганзгалах
- зэрэг өвөрмөц хэллэг;
- хургандаа цадаагүй бол төлгөндөө майлах
- хана үдмээр;
- ясан хэдрэг;
- хургаа голсон хонь (ботгоо голсон ингэ);
- яргуй хөөсөн ямаа;
- үнсэнд хаясан шалз;
- өрөмний өт;
- салхидсан тэмээ

зэрэг зүйрлэсэн холбоо үг, задлаг хам бүтэц, бэсрэг хэллэгүүд нь зөвхөн нүүдэлчин монгол үндэстний уламжлалт соёл, аж төрөх ёс, ёс заншил, тэдгээрийг уламжлан хөгжүүлэх явцад бий болсон ухаан билэг, оюун сэтгэхүй, сэтгэлгээний онцлогтой салшгүй холбоотой үүсч, хэрэглэгддэг байна.

Харин өөр соёл-хэлт үндэстэн угсаатны хувьд дээрх өвөрмөц хэллэг, зүйрлэлээр илэрхийлж байгаа утга санааг бас л өөрийнхээ хэлний ямар нэг нэгж, хэрэглүүрээр бүрэн дүүрэн илэрхийлэх боломжтой нь эргэлзээгүй. Харин ямар утга санааг илэрхийлэхдээ ямар зүйлийг ямар зүйлтэй адилтган зүйрлэж буй зүйлүүд нь харилцан адилгүй байхаас өөр аргагүй байдаг ажээ. Жишээлбэл, монгол хэлний “*хорголоо тоолох, нарийндаа хатах, алга дээш нь харуулж үзээгүй, гаднах нь гэртээ, гэрдэх нь гэдсэндээ ороогүй*” гэх зэрэг хэллэгүүд ерөнхий утга санаа нь “*харамч*” хэмээх нэг л концептэд хураагдана. Гэтэл үүнийг хятад хэлэнд “*төмөр тахиа*” гэдэг зүйрлэлээр илэрхийлдэг ажээ. Төмөр тахианаас өд ч, өндөг ч авч чадахгүй учраас ийн “*харамч*” хэмээх утга санааны илэрхийлэл болдог байна. Тэгвэл орос хэлэнд “*Өвлөөр цас гуйх боломжгүй (хүн) (у него зимой снега не-выпросишь)*” гэдэг нэг хэллэгээр илэрхийлдэг байна.

Энэ мэтийн үзэгдэл үндэстэн үндэстний аж төрж ирсэн газар нутгийн тогтоц, түүнд амьдрах ан амьтан, ургамал мод, тэнд аж төрж ирсэн үндэстэн ястны бүтээн цогцлоож, өвлөн уламжилж ирсэн эдийн ба оюун билгийн соёлын зүйл, шашин шүтлэг, элдэв ёс заншил, нийгэмшлийн төлөв байдал, түүнтэй холбоотой элдэв хорио цээр, дагаж баримталдаг элдэв зан үйл зэрэг нь тус бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтой байдагтай холбоотой байна. Үүнийг орчин үед “*харьцуулсан буюу зэрэгцүүлсэн хэлний соёл судлал*” (Сравнительная или сопоставительная лингвокультурология) хэмээх шинэ салбар ухааны хүрээнд судлан тайлбарлах болжээ.

Аливаа үнэлгээ (оценка) нь “*ертөнцийн дүр зураг*”-ийн үнэт шинж оршин байхтай зайлшгүй хамаатай байна хэмээн Е.М.Вольф¹¹ бичжээ. Түүний үзлээр энэ үнэлгээ (оценка) нь уг юмтайгаа, түүний тухай сэтгэлгээний тогтвортой хэв маяг (стереотип)-тай зайлшгүй уялдаатай оршдог гэж тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, аливаа юмын шинжийг уг юмнаас нь ангид сэтгэх аргагүй гэдэгтэй холбоотой байна. Гэвч нэг юмын тухайн нэг шинж нь харилцааны зорилго, орчин нөхцөл зэргээс хамаараад хоёрдмол утгатай болдог тохиолдол байдаг ажээ. Жишээлбэл, “*унасан газраасаа шороо атгадаг (хүн)*” гэвэл, “*овсгоо самбаатай, аминдаа арчаатай, арга ухаантай*”-г илэрхийлсэн эерэг үнэлэмжтэй байхаас гадна “*зальжин овжин, зальжин овсгоотой, зальжин*

¹¹ Вольф У.М. *Функциональная семантика оценки.*, М., 1985. х.204.

самбаатай” гэх зэргээр “зальжин” шинжий нь онцолсон, сөрөг үнэлэмжээр хэрэглэгдсэн байж болно.

Ийм тохиолдолд хоёрдмол утгатай хэлний тэмдгийн хэлбэр нь ижил, гагцхүү харилцааны үүрэг нь өөр өөр байх болно. Үүнийг “хоёрдмол хувилбар” (амбивалентность) хэмээн нэрлэх нь бий.

Хэлц нэгж болон үнэлэх утга санаа агуулсан бусад нэгжүүдийн нэрлэлтийн (денотатив) агуулга үнэлэмж ямар шинжтэй, ямар үүрэгтэй оролцдог вэ? гэдэг асуултын тухайд судлаачдын санал нэг мөр болоогүй гэж үздэг байна.

Хэлний тухайн илэрхийлэл, ялангуяа хэлний хийсвэрлэлийн дээд төвшний нэгж болох хэлц нэгжийн агуулгад бодит байдлын юм үзэгдлийн аль нэг зүйлийн бодит шинж ба түүнийг тусгасан ухагдахууны хэлбэр зайлшгүй агуулагдаж байдаг учраас уг юм үзэгдлийн бодит шинжийг нэрлэхийн хамтаар дохиожуулан тодорхойлсон утга нь үүнтэй нягт уялдаатай оршиж байх ёстой гэж үздэг ажээ. Өөрөөр хэлбэл, хэлц нэгжийн тухайд үнэлэмжийн утга нь нэрлэн-дохиожуулсан шинжтэй байна гэж үзэж байна. Гэвч хэлний илэрхийлэл бол зонхидоо рационал буюу сэтгэл хөдлөлийн бус тэмдэглэхүүн байдаг бөгөөд цэвэр сэтгэл хөдлөлийн үнэлэмж гэж хэлэнд бараг байдаггүй¹² гэсэн саналыг уг үзэгдлийн мөн чанарт илүү нийцэхүйц үзэл баримтлал хэмээхийг тэмдэглэсэн судлаач ч байна. Энэхүү үзэл баримтлалын гол агуулга нь юу вэ? гэвэл ерийн үнэлэмж (рациональная оценка), сэтгэл хөдлөлийн үнэлэмж (эмоциональная оценка) хэмээх ялангуяа үзэхдээ хэлний илэрхийллийн зонхи нь ерийн үнэлэмжийг агуулдаг гэдгийг онцлон тэмдэглэхэд хамаатай байна гэж үзмээр байна.

Учир нь ерийн үнэлэмж нь нэрлэгдэж буй юм үзэгдэл болгон ямар нэг үнэт шинжийг бодитой агуулдаг болохыг зайлшгүй заана. Энэ нь уг юм үзэгдэл, түүний шинж байдлын тухай учир зүйн бодомжийн агуулгаар тодорхойлогдож байгаа үзэгдэл гэж үзэх ёстой ажээ. Ийм учраас энэхүү үнэлэмж нь хэлний утгат нэгжийн нэрлэн дохиожуулах агуулгын зайлшгүй нэг бүрэлдүүлбэр болох ёстой гэсэн Т.Г.Никити-нагийн саналыг¹³ монгол хэлний хэлц нэгжийн утгын онцлог мөн чанарыг тодорхойлохдоо иш үндэс болгосныг тэмдэглэе.

Өөрөөр хэлбэл, шинж заасан дан үгээр илэрхийлсэн нэрлэлт болгон үнэлэмжийн утгыг ямар нэг байдлаар агуулсан байдаг гэж үзэж болно. Жишээлбэл, “зожиг” гэдэг нэрлэлтийн ерийн үнэлэмж нь “таагүй” хэмээх санаа болно. Өөрөөр хэлбэл, “зожиг” зан, “нийтэч” (хамтач) зангийн аль нь сайн бэ? гэсэн асуултын хариулт нь: - “нийтэч (хамтач)” нь сайн байлгүй яах вэ! “зожиг” зантай байвал муу/муухай шүү дээ! гэсэн шиг үнэлэмжтэй байх нь эргэлзээгүй юм.

Үүнтэй холбогдуулж нэг зүйлийг онцлон тэмдэглэвэл, монгол хэлний өвөрмөц хэллэгээр илэрхийлж байгаа юм үзэгдэл, шинж чанарыг үнэлэмжийнх нь эерэг, сөрөг талаас эсрэгцүүлж ажиглавал өвөрмөц хэллэгээр илэрхийлж буй шинж чанарын олонхи нь ялангуяа хүний зан чанарын сөрөг шинжид хамаатай зүйлийг олон талаас нь үнэлэн тодорхойлсон байдаг. Харин эерэг шинжийн тухай өгүүлэмжтэй хэллэг харьцангуй цөөн байдаг нь бас нэг сонирхолтой асуудал болно.

Өмнө тэмдэглэснээр аливаа хэлц нэгжид хоёр зүйлийн үнэлэмж утга байна. Энэ нь:

1. Ерийн үнэлэмж

¹² Вольф.Е.М. Функциональная семантика оценки. М., 1985 х. 40

¹³ Никитина Т.Г. Специфика фразеологической номинации // Проблема фразеологической семантики. СПб. 1996. х.69-94.

2. Сэтгэл хөдлөлийн үнэлэмж болно. Жишээлбэл, “тэнэг” гэхийг “эргүү”, “мулгүй”, “маанаг”, “элий”, “балай”, “харанхуй” гэх мэт ойролцоо утгатай дан үгээр илэрхийлэхээс гадна,

- Хоёр үгний утга мэдэхгүй
 - Хоймсон дээсний эрч эрхээхгүй
 - (Гурван үгний утга мэдэхгүй
 - Гурамсан дээсний эрч эрхээхгүй);
 - Ухаанд нь ухна, сэтгэлд нь сэрх үхсэн;
 - Ухаан нь ууцандаа орсон;
 - Тархи (толгой) нь эргэсэн;
 - Азаргаа унаад адуугаа эрсэн;
 - Эргүү төлөг (эргүү мал);
 - Төөрсөн төлөг / төөрүүлсэн нохой
 - Усан (махан/ хөндий/ хоосон) хөлдүү толгой;
 - Хойшоо харсан нүх;
 - Арилсан дотортой;
 - Богино жолоотой;
 - Доодохоосоо долоон доор
- гэх мэт олон хэллэгээр илэрхийлж болно.

Үүний “тэнэг” гэдэг нь ерийн үнэлэмж бүхий нэрлэлт, харин удаах жагсаан үзүүлсэн нь сэтгэл хөдлөлийн үнэлэмж бүхий нэрлэлтэд хамаарна гэж үзэж байна.

Гэвч сэтгэл хөдлөлийн үнэлэмж бүхий тэдгээр хэллэгүүд нь уг шинж чанарын талаар өгүүлэгчийн хандлага үнэлэмж ямар байгааг илүү нарийн тодорхой илэрхийлэх шинжээрээ өөр хоорондоо ялгаа бүхий олон янзын утгын өнгө аяс илэрхийлэх боломжтой байх болно. Жишээлбэл, “Азаргаа унаад адуугаа эрэх” гэдэг нь ер нэг тэнэг шинжийг илэрхийлэх төдий биш, харин **ёжилж егөөдсөн, тоглоом шоглоом, доог тохуу хийх** аясаар хэрэглэх бол, “*усан/махан/хөндий/хоосон/хөлдүү толгой*” гэвэл доромжлон доршоож үзсэн, харин “*хойшоо харсан нүх*”, “*ухаанд нь ухна, сэтгэлд нь сэрх үхсэн*”, “*доодохоосоо долоон дор*” гэвэл харааж зүхсэн аястай, “*хоёр үгний утга мэдэхгүй, хоймсон дээсний эрч эрхээхгүй*”, “*арилсан дотортой*” гэвэл ерөнхийлөн тодорхойлсон, “*богино жолоотой*”, “*төөрсөн гөлөг*” гэвэл өрөвдөж харамссан аясаар (зорилгоор) хэрэглэх зэргээр үнэлэмжийн утгын олон янзын өнгө аясыг илэрхийлэх боломжтой байдаг.

Эндээс үзвэл хэлц нэгжийн үндсэн онцлог, гол үүрэг бол юм үзэгдэл, үйл байдал, хэрэг явдал, шинж чанарыг нэрлэх төдий биш, харин аль нэг шинжийг онцлон тодорхойлох, бүр тодруулан хэлбэл, уг юм үзэгдэл, шинж чанарт хэрхэн хандаж, түүнийг хэрхэн үзэж үнэлж байгаагаа илэрхийлэх зорилгоор тухайн хэлцийг үүсгэн хэрэглэдэг хэмээн судлаачид онцлон тэмдэглэсний учир үүнд оршдог байна.

Гэвч сэтгэл хөдлөлийн байдал буюу үнэлэмжийг илэрхийлэх энэ утга нь хэлц нэгжийн нэрлэн-дохиожуулах агуулгад багтахгүй, харин хамсмал утга (коннотация)¹⁴ –

¹⁴ Коннотация хэмээх энэ нэр томъёог үгчилж буулгавал “хамсмал утга” гэж болмоор, утгачилан буулгавал “онцолмол утга” ч гэж болмоор байдаг. Харин В.Н. Телия уг үгийн гарлыг “co-notare” хэмээх нийлмэл бүтэцтэй, франц гаралтай үгээс үүссэн, “co-” нь “хам, цуг” хэмээх утгатай, “notare”-нь тэмдэглэх гэсэн шиг утгаас гаралтай хэмээн 1996 онд хэвлүүлсэн “Русская фразеология” номондоо тэмдэглэсэн байна.

ын хүрээнд хамаарах үзэгдэл бөгөөд уран яруу илэрхийлэх өнгө аясыг бүтээх хэрэглүүр гэж үзэх ёстой хэмээн¹⁵ тэмдэглэсэн байна.

Өөрөөр хэлбэл, В.Н. Телия-гийнхаар энэхүү хамсмал утга (онцолмол утга) гэдэг нь үгийн сан, хэлц хэллэгт өөрт нь анхнаасаа байдаггүй, түүний үндсэн утга биш, харин харилцахуйн тодорхой зорилго, тодорхой орчин нөхцөлөөс үүдэж бий болох “олдмол” утга гэмээр үзэгдэл ажээ. Ийн учраас коннотаци нь “эгдүүцэн дургүйцэх, үзэн ядаж, жигших, хорсож зэвүүцэх, басамжилж тохуурхах, ёжилж егөөдөх, бахархаж хөөрөх, харааж зүхэх, ойшоож тоох” зэрэг сэтгэл хөдлөлийн олон янз байдлыг илэрхийлэхэд хамаатай үзэгдэл гэж үзэх ёстой ажээ.

“Коннотация” хэмээх уг асуудлын талаар В.Н.Телия дэлгэрүүлэн өгүүлэхдээ: Коннотаци бол денотаттай ч, бас хэлцийн гадаад дотоод хэлбэртэй ч нэгдэн нийлж, хоёр зүйлийг өөр хооронд нь жишин харьцуулах сэрэл мэдрэхүй, сэтгэц физиологид зайлшгүй үүсэх авалцуулан дүрслэх шалтгаалалцмал үйлдлээр “тэжээгдэн тэтгэгдэж” байдаг үзэгдэл юм.

Харилцах үед хэлц нэгжээр нэрлэлт үүсэх явцад денотация, коннотация буюу нэрийдмэл утга (денотаци), онцолмол утга (коннотаци) хоёр харилцан нөлөөлөл, бодот байдлын (юм үзэгдэл, үйл байдал, хэрэг явдал, шинж чанар зэргийг бүхэлд нь) бодит шинж чанар хийгээд түүний тухай ерийн үнэлэмж, сэтгэл хөдлөлийн байдлыг илэрхийлсэн үнэлэмж зэрэг нь өөр хоорондоо ямар харьцаа хамааралтай байгааг илэрхийлдэг¹⁶ хэмээн тодорхойлсон байна.

Иймээс хэлц нэгж болон энэ төрлийн бусад зарим нэгж нь сэтгэл хөдлөлийн байдлыг илэрхийлсэн онцолмол утгатай байх нь тэдгээр нэгжийн хэвшинжит онцлог ажээ.

Харин Т.Г.Никитина “сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн нэрлэлт” (эмотивная номинация) гэхийн оронд онцолмол (утгатай) нэрлэлт (коннотативная номинация) гэх нь зүйтэй гээд ингэж нэрлэвэл төрлийн нэр, зүйлийн нэр хоёрыг зааглаж, тодорхой болгоход дөхөмтэй юм. Жишээлбэл, орос хэлэнд “ухаантай (умный)” гэвэл саармаг үнэлэмжийг буюу ерийн үнэлэмж бүхий нэрлэлт бол, “долоон сөөм духтай” (семи пядей во лбу) гэвэл онцолмол нэрлэлт болно¹⁷ гэжээ.

Үүнийг монгол хэлцээр жишээлэн үзвэл: “Дуугүй” гэвэл ерийн нэрлэлт, харин

- Бүлх залгисан (юм шиг);
- Ус балгасан (юм шиг);
- Дүлий дүмбэ оргих;
- Амаа үдүүлсэн (юм шиг);
- Хэл нь татсан (юм шиг);
- Амнаас нь алт уначих гэж байгаа юм (шиг);
- Дуугаа хураасан (юм шиг);
- Амаа хамхисан
- Ам ангайхгүй

гэх зэрэг нь онцолмол нэрлэлт болох юм.

Үүнтэй нэгэн адилаар “зожиг, доён, зөрүүд, ярдаг” гэх зэрэг ойролцоо утгатай үгээр илрэх нэрлэлт нь саармаг үнэлэмжтэй нэрлэлт бол,

¹⁵ Телия В.Н. Коннотативный аспект семантики номинативных единиц. М., 1986. х. 5

¹⁶ Телия В.Н. Коннотативный аспект семантики номинативных единиц. М., 1986. х.16; 133

¹⁷ Никитина Т.Г. Специфика фразеологической номинации //Проблема фразеологической семантики. СПб. 1996. х.79

- Буруу ишилсэн сүх;
- Буханд ачсан ачаа;
- Хүнээс гадуур, тэмээнээс гэдгэр;
- Дөргүй бух;
- Хүний хэлэл, нохойн хуцал болох;
- Гон бие, гозон толгой;
- Чихгүй толгой

гэх зэрэг нь онцолмол нэрлэлт буюу сэтгэл хөдлөлийн байдлыг илүү тодорхой болгон илэрхийлсэн хэллэг гэж болно.

Хэлц нэгжийн утгын онцлогийг тодорхойлоход зайлшгүй анхаарах ёстой өөр нэг асуудал бол яруу илэрхийлэх шинж, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх үнэлэмж хоёр ямар харьцаа хамааралтай болохыг тодруулах явдал юм.

Тэгвэл яруу илэрхийлэх шинж гэдэг нь сэтгэл хөдлөлийг илэрхийлэх шинжээс илүү өргөн агуулгатай ойлголт гэж үздэг бөгөөд сэтгэл хөдлөлийн өнгө аястай хэлний нэгж болгон нь яруу илэрхийлэх зайлшгүй үүрэгтэй байна. Харин яруу илэрхийлэх үүргээр хэрэглэгдсэн нэгж болгон нь заавал сэтгэл хөдлөлийн байдлыг илэрхийлсэн байх албагүй¹⁸ гэсэн санал байдгаас үзвэл яруу илэрхийлэх үүрэг бол сэтгэл хөдлөлийг илэрхийлэх үүргээ дотроо багтаасан ойлголт хэмээн үзэх ёстой болж байна. Ингэхдээ сэтгэл хөдлөлийг гагцхүү илэрхийлсэн хэлц нэгж хэлэнд цөөнгүй байдгийг бас анхааралгүй өнгөрөх аргагүй юм. Ийм нэгж нь уламжлалт хэлшинжлэлд “*аялга үг*” хэмээн ангилан тодорхойлдог илэрхийллүүдэд хэвшинжтэй байдаг ажээ. Ийм нэгжийг ХХ зууны II хагасаас “*аялга үг*” биш “*аялга өгүүлбэр*” (Ш.Лувсанвандан), “*мэдрэхүйн өгүүлбэр*” (М.Базаррагчаа) хэмээн тодорхойлох болсон байна. Жишээлбэл, Заяа нь дэлгэр!, Тосоор гоож!, Буянаа нэм!, Зайлуул!, Харламар!, Хүүдий! гэх мэт хам сэдвээсээ хамааран “*цочиж балмагдсан, сандарч тэвдсэн, айж ширвэгдсэн, биширч гайхсан, харамсаж гутарсан*” зэрэг сэтгэл хөдлөлийн янз бүрийн өнгө аясыг илэрхийлэх хэллэгүүд үүнд хамрагдах боломжтой.

Хүний сэтгэл хөдлөлийн байдлыг илэрхийлдэг хэлц нэгжийг Р.И.Яранцев хэд хэдэн хэсэг болгон ангилж, харгалзах хэллэгүүдийг жишээлэн тайлбарласан байна¹⁹. Түүний ангиллыг үзүүлбэл:

1. Шагшин гайхах, хөгжин хөөрөх, баярлан баясахыг илэрхийлсэн бүлэг;
 2. Ойшоон тоох, сайшаан ерөөхийг илэрхийлсэн бүлэг;
 3. Гайхан мэлрэх, аймран алмайрахыг илэрхийлсэн бүлэг;
 4. Адлан шоолох, үл тоомсорлон дургүйцэх, жигшин жихүүрхэхийг илэрхийлсэн бүлэг;
 5. Эгдүүцэн зэвүүцэх, бухимдан хорсохыг илэрхийлсэн бүлэг;
 6. Уурлан хорсох, жигшин зэвүүцэхийг илэрхийлсэн бүлэг хэмээн ангилсан байна.
- Одоо сэтгэл хөдлөлийн байдлыг илэрхийлсэн монгол хэлний хэлцээс жишээлж, тэдгээрийг утгазүйн ерөнхий орон буюу нэг төрлийн багцалсан мэдлэг (концепт) үүсгэх онцлогоор нь ангилан үзүүлэхийг оролдъё. Жишээлбэл;

1. Айх цочих зүйл:
 - Үнхэлцэг нь хагарах шахах;
 - Сүнс нь зайлах;

¹⁸ Кунин А.В. Курс фразеологии современного английского языка. М., 1986. х.153.

¹⁹ Яранцев Р.И. Словарь-справочник по русской фразеологии. М., 1985.

- Нүд нь орой дээрээ гарах;
- Толгойтой үс нь босох;
- Гол нь зарс хийх;
- Голоор нь хүйт оргих;
- Нуруугаар зарс хийх;
- Царай нь зэвхийх (цонхийх);
- Зүрх амаар гарчих шахах;
- Зүрх нь хагарах шахах;
- Нүүрнийх нь үс босох гэх мэт.

Үүнд холбогдуулж, нэгэн зүйлийг тэмдэглэвэл: Айх үед хүний судас огцом агшсанаас болоод захын мэдрэлийн судасны цусны хангамж муудсанаас шалтгаалж, хоёр зүйлийн даралтын зөрөө огцом ихсэхэд бие, ялангуяа нуруугаар гэнэт хүйт оргих шиг, гол нуруугаар ямар нэгэн юм зарсхийх шиг, эсвэл нүүрний үс, толгойн оройн үс босох шиг мэдрэмж өөрийн эрхгүй төрөх, ийн гэнэт цочсон, айсан хүний царайг ажиглавал нэгэнт захын мэдрэлийн судас огцом агшиж, түүний цусны хэмжээ хомсдосноос болоод царай зүсний байдал цайх, цайрах, улмаар цонхийх, зэвхийх, эсвэл хөхөлбөр зэвэргэн болж үзэгдэх нь зайлшгүй. Энэ бол хүний бие цогцост үүсч буй сэтгэц-физиологийн зайлшгүй нөлөөтөл, хамаатал, харилцан үйлчлэлийн үр дүн ажээ. Харин хүний сэтгэц-физиологийн энэхүү онцлогийг хэлний илэрхийллээр ингэж тодорхойлон нэрлэж байгаа нь нэн сонирхолтой асуудал юм.

Тэгвэл “ичих зовох”-ыг илэрхийлсэн хэлцүүд нь:

- Ичсэнээсээ болоод;
- нүүрээ хийх газраа олж ядах;
- нүүр нь улайх;
- нүүр халуу оргих;
- нүүр шатах шахах;
- нүүр түлэгдэх;
- ичих нүүрэндээ илэг наасан гэх мэт хувилбартай байдаг. Сэтгэлзүйн

үүднээс, Ю.Д.Апресяны²⁰ тэмдэглэснээр, **айх цочих ба ичих зовох** хоёрыг ялгахад төвөгтэй ч гэсэн сэтгэц физиологийн хувьд эсрэг тэсрэг илрэлтэй үзэгдэл ажээ. Ийм учраас айж цочих үед судас огцом агшиж, судсан дах цус захаасаа төв (гол) руугаа эргэж урссанаас хүний арьсны гадна хэсэг, ялангуяа нүүрний арьс цонхийн цайх юмуу, арзасхийх, зарс хийх мэдрэмж төрдөг бол ичиж зовох үед үүний яг эсрэг сэтгэц-физиологийн үйлдэл болдог учраас **бие нүүр халуу оргих** иймээс тухайн үзэгдлийг хэтрүүлэн илэрхийлэхдээ **нүүр шатах, түлэгдэх шахах** ингэснээс болоод **нүүрээ хийх газраа олж ядах**, ийм мэдрэмжгүй хүнийг **ичих нүүрэндээ илэг наасан** хэмээн хэлэлцдэг үг үүссэн нь учиртай ажээ. Өөрөөр хэлбэл, зарим хэлц, ялангуяа хүний сэрэл мэдрэхүй, сэтгэл хөдлөлийн байдлыг илэрхийлсэн хэллэгүүдийн утгыг нарийвчлан шинжлэхдээ уг үзэгдэл үүсч бий болох сэтгэц-физиологи, сэтгэц-мэдрэл, сэтгэц-сэтгэлгээ, сэтгэц-танин мэдэхүйн онцлог зэргийг заавал анхаарч үзэх хэрэгтэй гэдгийг Ю.Д.Апресян нарын судалгаа онцолж өгсөн байна.

2. Уурлаж багтрахын зүйл:

- Шар нь хөөрөх/хөдлөх/буцлах/бадрах;

²⁰ Ю.Д.Апресян *Образ человека по данным языка: попытка системного описания* // Вопросы языкознания 1995. №1

- Хор нь буцлах;/хөдлөх;
- Шээс нь гоожих;
- Дотор арзганах;
- Уур нь хүрч, уушиг нь сагсайх;
- Хагарчих шахах (дэлбэрэх шахах);
- Багтаж ядах гэх мэт.

Ташрамд дурдахад “уурлах” гэдэг концептийг америкийн англи хэлээр “Steam” буюу “уур хий”-тэй адилтгасан байдаг нь агуулгаараа хятад хэлэнд уг концептийг илэрхийлэх агуулгатай тохирдог хэмээн тэмдэглэсэн байна²¹.

Монгол хэлний дээрх хэллэгийн жишээг ажиглахад “уурлах” хэмээх концептийг илэрхийлсэн хэллэгүүдийн бүрэлдүүлбэрт (шар нь) **хөөрөх, буцлах, бадрах, “хагарах (шахах), дэлбэрэх (шахах), уур нь хүрч уушиг нь сагсайх**” гэх мэт ямар нэг зүйл халж тэлснээс уур хий мэтийн дэгдэмхий зүйл үүсэх утга санааг агуулсан байгаа нь сонирхолтой юм.

Энэ бол зарим зүйлийн талаарх өөр өөр үндэстэн угсаатны сэтгэлгээ нийтлэг хэв маягтай байж болохыг гэрчилж буй баримт гэж үзэж болно.

Үүнчилэн санаа муутай, тэгсэн хэрнээ түүнийгээ хэнд ч мэдэгдүүлэхгүйг хичээж байдаг нэгэн зүйл атгаг санааг орос, англи хэлэнд хэлбэр-бүтэц, утга агуулга нь яг тохирдог, үгчилбэл, “*хонины арьс нөмөрсөн чоно*” гэдэг хэллэгээр илэрхийлдэг байна. Энэ хэллэг монгол зарим нийтлэлч, зохиолчдын бичсэн зүйл, хүмүүсийн хэл ярианд цөөнгүй тааралдах болсон нь англи, орос зэрэг европын хэлнээс тэр чигээрээ орж ирсэн хэллэг бололтой.

Гэвч аль тивд байдаг ямар зүйлийн чоно ч гэсэн аль ч тивийн ямар ч зүйлийн хонийг “*гэнэдүүлэн*” барьж идэх нь уг амьтдын байгалиас заяасан, төрөлхийн шинж учраас уг үзэгдлийг тусган төсөөлж, оюуны дүгнэлт хийсэн энэ адилтгал, дэлхийн бөмбөрцөгийн аль ч тивд оршин суудаг, ёс заншил, соёл, хэлээрээ ялгаатай, аль ч үндэстэн угсаатанд нийтлэг, нэг ижил ухааралт болсоноороо өөр өөр соёл-хэлт үндэстэн дундын нийтлэг сэтгэлгээний хэв маягийг илэрхийлэх хэлний тэмдэг болон хэрэглэгдэх болсон байна гэж хэлж болно.

Үүнтэй уялдаад бодит байдлыг юм үзэгдэл, шинж чанарыг хэсэгчлэн нэрлэх үү, эсвэл үйл явдлыг тэр чигээр нь нэрлэх үү? гэдэг асуудлыг хэлцийн утгатай дан үг, эсвэл өвөрмөц хэллэг (хэвшмэл хэллэг)-ийн алинд нь холбоотой авч үзэх вэ? гэдэг нэг асуудал гарч болно.

Тэгвэл үүний эхнийх нь хэлцэжсэн утгатай дан үгээр илэрч, удаах нь өгүүлбэрийн бүтэцтэй хэллэгээр илэрдэг байна. Жишээлбэл, “*Харганы унгасаар эсгий хийх*” гэдэг нь “*бүтэшгүй зүйлээр оролдож цаг заваа дэмий үрэх*” гэсэн санаа, “*өдөр алдсанаа шоно эрэх*” гэдэг нь (эрхшээхэд) *хялбар цагт нь эс чадах зүйлээ хэцүү цагт бүтээхийг оролдох, энэ нь ер бүтэхгүй зүйл гэсэн санаа; “ниргэсний хойно хашиграв гэгч*” гэдэг нь *хэрэг явдал нэгэнт өнгөрсөн хойно гэмших* гэсэн санааг тус тус илэрхийлсэн болно.

Гэтэл үүний эсрэгээр, **алтан хошуу өргөх** гэвэл ховлох~ хов зөөх-тэй тохирдог, **шүлсээрээ ундалж, шүдний махаараа хооллох** гэх буюу “*өтгөн шүлсээрээ хооллож, шингэн шүлсээрээ ундах*” гэвэл ядрал зүдрэхийн туйлд хүрэх, **туйлдах** гэдэгтэй тус тус утга санаа дүйх байдалтай болно.

²¹ G. Lakoff G., Jonhson M *Metaphory We Live .by.* Chicago, 1980

Ийм учраас өгүүлбэрийн бүтэцтэй хэллэгийн зарим нь нөхцөл байдал (ситуаци)-ыг бүхэлд нь (нэрлэдэг) илэрхийлдэг, зарим нь юм үзэгдлийн аль нэг шинжийг буюу бодит байдлыг хэсэгчлэн нэрлэх (илэрхийлэх) онцлогтой байна гэж үзэж болно. Гэвч амных нь сална арилаагүй (тахимных нь баас хатаагүй) гэх зэрэг өгүүлбэрийн бүтэцтэй хэллэг нь “балчир” гэсэн дан нэрлэлттэй утга дүйж болно. Гэвч энэ нь зөвхөн “балчир”-ыг нэрлэж байгаа бус, харин “*турилага мэдлэг суугаагүй, хэрсүүжснэ хаширжаагүй, энэ шинжээрээ бага балчир хүүхдийн төвшинд байгаа. Бас ийм байгаа нь зохисгүй*” гэсэн бүхэл бүтэн өгүүлэмж (цогцолбор)-ийн санааг илэрхийлж байгааг анзааралгүй өнгөрч болохгүй.

Үүнээс үзвэл, хэлцийн утга бол юм үзэгдэл, шинж чанар, нөхцөл байдлыг нэрлэхийн зэрэгцээгээр тодорхойлох үүрэгтэй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл нэрлэлт нь тэмдэглэхүүний үүрэгтэй, харин утга нь тодорхойлох, онцлох үүрэгтэй байдаг гэж болох юм. Үүнээс үзвэл тодорхойлох буюу онцлох үүрэг нь хэлцийн нэг үндсэн шинж, бүр тодорхой хэлбэл, нэг үндсэн ай (категори) гэж үздэг байна.

Үүний нэгэн адилаар “*дэлхийн шороог дээш нь цацавч доошоон, дэнгийн галыг доош нь харуулавч өөдөөн*” гэх зэрэг өгүүлбэрийн бүтэцтэй зүйрлэсэн хэллэгүүд нь их төлөв нөхцөл байдал, учирзүй хэрэг явдлыг илэрхийлсэн байна.

Ийм учраас монгол хэлний зүйрлэсэн хэллэг буюу зүйр цэцэн үгийн гүн санааг тусгайлан судлуштай зүйл юм. Газар дэлхийн татах хүчин, юмын жин масс, тэдгээрийн хоорондын харьцаа хамаарлын зайлшгүй зүй тогтлын нэг онцлогийг дээрх хэллэгээр илэрхийлсэн байна. Үүний нэгэн адилаар, “*хүнийг хангалж мэднэ, хүлгийг унаж мэднэ*” гэдэг хэллэгийн утга нь “*бүх юм тодорхой харьцаа хамааралд оршино. Өөрөөр хэлбэл, харьцаанаас ангид юм үзэгдэл гэж үгүй, тэгвэл юм үзэгдлээс ангид харьцаа ч гэж үгүй*” гэсэн утга санааг Ш.Лувсанвандан фонем, морфем, тэдгээрийн хувилбарыг тодорхойлохдоо маш тов тодорхой үлгэрлэн үзүүлсэн нь их чухал санаа юм. Хэлц нэгжийн утгыг тайлахад ч гэсэн энэ харьцаа хэмээх ойлголт ихээхэн учир холбогдолтой байна.

SUMMARY

Analyzing denomination in an extensive range, it can be formed by any word, compound word, analytical construction, idiom, phrase or sentence and micro-discourse of a certain subject. Therefore, it is necessary to study the peculiarity of phrase-unit denomination as a denotation (ideal).

Denomination expressed by idioms is not the name of a thing or group, but it has characteristics to nominate evaluation and attitude to the things.

The emotional and imaginative association surrounding a word is connotation. It is created when you mean something else, something that might be initially hidden depending on a certain environment and certain objective of communication. It intends the various emotional reactions like to be annoyed, hatred, feel resentful, humiliate, satirize, curse, be proud of, esteem etc.

Connotation and denotation are main principal methods of describing the meanings of words, so they should be considered as a new paradigm in stylistics.